

ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖАГСААЛТ

Д/д	Дээд байгууллагын шийдвэр, огноо	Оны хязгаар	Нэрийн өөрчлөлт
1	2	3	4
1	УБ хотын АДХГЗахиргаа, БНМАУ-ын Сангийн яам, Ардын Боловсролын яамны коллегийн хамтарсан хурлын 257/291/325 тоот тогтоол	1980-1992	Сүхбаатарын районы сургууль цэцэрлэгийн нэгдсэн аж ахуй
		1992-1999 он	"Залаат"УҮГ
		2000-2006.06	"Сүхжанжин"УҮГ

Нэг. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

1978 онд Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны гишүүд, БНМАУ-ын Сангийн яам, Ардын боловсролын яамны коллегийн хамтарсан хурлын 257/291/325 тоот тогтоолын дагуу Сүхбаатарын районы ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нэгдсэн аж ахуйн төв нэртэйгээр байгуулагдан 1990-ээд оны сүүл хүртэл үйл ажиллагаа нь явагдаж иржээ.

Дээрх тогтоолын дагуу байгуулагдсан нэгдсэн аж ахуйн даргаар Н.Жамбалсүрэн томилогдон ажиллаж байжээ.

Ингээд 1992 онд Үндсэн хууль өөрчлөгдөж, түүнд нийцсэн "Аж ахуйн нэгж компанийн тухай" шинэ хууль гарснаар нэгдсэн аж ахуйн төвүүд нь бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөж, компанийн зохион байгуулалтаар ажиллах болсон билээ.

аж байжээ. Улс орон зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн он жилүүдэд тус аж ахуй нэгж үйл ажиллагаагаа мөн зах зээлийн зарчимд шилжүүлж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байжээ. Гэтэл тус байгууллага нь жил ирэх ту

Сүхбаатарын районыг 2 дүүрэг болгон хуваагдахад цэцэрлэг, сургуулиудын нэгдсэн аж ахуйн төвүүд татан буугдаж, дүүрэг бүрийн Засаг даргын захирамжаар тус бүрдээ "Бүрэн бус хариуцлагатай компани"-ууд байгуулагдаж, дүүргийн Засаг даргын захирамжаар компанийн захиралуудыг тус бүрд нь томилсон байна.

1992 оноос Бүгд найрамдах Монгол ард улсын "Аж ахуй нэгжийн тухай" шинэ хуулийн дагуу "Залаат" нэртэй компани болж захирлаар нь Ц.Дангаасүрэн томилогдон 1996 он хүртэл ажиллаж байжээ.

Гэтэл тус байгууллага нь жил ирэх тутам аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа нь доголдож санхүүгийн чадавхи нь суларч удирдлага менежмент дутагдахын хэрээр эргэлтийн хөрөнгийн эх үүсвэргүй болж бусад байгууллага аж ахуйн нэгжүүд, иргэдэд төлөх өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж 1997 -1999 оны 09 дүгээр сар хүртэл үйл ажиллагаа нь бүрэн зогсож 1996-1998 оны хооронд 3 захирал солигдож өмч хөрөнгө шамшигдаж цагдаа шүүхээр хянагдсан боловч тодорхой үр дүн гараагүй байна.

Дүүргийн засаг даргын тамгын газраас тодорхой бодлого явуулж дэмжин үйл ажиллагааг нь 1999 оны 9 сараас хүүхдийн хоолонд батлагдсан эх үүсвэрийг урьдчилан санхүүжүүлэх замаар олгож хангалт нийлүүлэлт хийлгэж эхэлсэн болно.

Ингээд 2000 оноос "Нөхөрлөл компанийн тухай хууль"-аар Сүхжанжин улсын үйлдвэрийн газар болсон.

Өмнөх жилүүдэд үүссэн өр төлбөрийг барагдуулах талаар Засаг даргын захирамж гаргаж комисс томилон ажилуулснаас гадна, буруутай өр төлбөртэй албан тушаалтнуудын асуудлыг эдийн засгийн цагдаагийн албанд өгч шалгуулах ажлыг хийсэн байна.

Сүхжанжин улсын үйлдвэрийн газар нь Сүхбаатар дүүргийн 23 цэцэрлэгийн 4000 гаруй хүүхдэд хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлдэг, хангамж үйлчилгээг хариуцахын зэрэгцээ төсвийн байгууллагуудын гал тогооны тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, аж ахуйн чанартай бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

Үйл ажиллагаагаа дүүргийн Засаг дарга, Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмнө хариуцан явуулж тайлагнаж дүгнүүлдэг байжээ.

Байгууллагын бүтэц орон тооны хувьд 11 ажилтан ажилладаг, захирал, нягтлан бодогч, менежер, аж ахуйн нярав, архив бичиг хэрэг, бэлэн мөнгөний нярав, хүнсний нярав, түгээлтийн нярав жолооч, тоног төхөөрөмжийн механик, цахилгаанчин, ачигч 2, манаач, сахиул тус бүр 1 ажиллаж байжээ.

Дээрх компаниудын үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж хөрөнгө санхүү эргэлтийн хөрөнгийн хувьд томоохон өөрчлөлт гарч түүнтэй холбогдох хуулиудад зохих өөрчлөлтүүд орсноор 1997 оноос компаниудын харъяалал, өмч хөрөнгө нийслэлийн өмчид бүртгэгдэх болсноор Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд болсон түүхтэй.

Иймээс дээрх үйлдвэрийн газрын өмч хөрөнгийг захиран зарцуулах ерөнхий эрх нь Нийслэлийн Иргэдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад шилжсэн байна.

Ингээд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 06 дугаар сарын 124 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 7 дугаар сарын 15-ний өдрийн 282 дугаар захирамжаар татан буулгасан. Ингэж татан буулгасан боловч дүүргийн засаг даргын захирамжаар үйл ажиллагаагаа хэвийн явуулсаар байсан.

НИТХТэргүүлэгчдийн 2006 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 154 дүгээр тогоолоор 2 дүүргийн хангамжийн газруудыг нэгтгэн "Багачууд хүнс" НӨҮГ нэртэйгээр үйл ажиллагаа нь үргэлжилж байна.